



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/64

Хэрлэн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн зөн Олон Улсын байгууллагын Бор-Өндөр 2 орон нутгийн хөтөлбөртэй хамтран зудын эрсдэл өндөр орон нутагт амьдарч буй зорилтот бүлгийн малчин өрхүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах эрт үеийн арга хэмжээ авч хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай :

Ажлын хэсгийн
ахлагч:

Н.Зоригтбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн
бичиг:

Г.Жаргалбат

"ДЗМОУБ-ын Бор-өндөр 2 Орон Нутгийн Хөтөлбөр"-ийн менежер

Гишүүд:

Г.Пүрэвбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Г.Ирээдүймөнх

Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Ч.Хонгорзул

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын нийгмийн халамжийн хэлтсийн дарга

Д.Бат-Эрдэнэ

Хэрлэн сумын Засаг даргын орлогч

Г.Баярмагнай

Онцгой байдлын газрын мэргэжилтэн

2. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга буюу Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\Захирамж-2024

231010157